



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар A/109

Булган

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.13 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 298 дугаар тушаал, аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2022 оны 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгаж байгаа байгууллагуудын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгаж байгаа байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, холбогдох хууль тогтоомж, тушаал, зааварт тусгагдсаны дагуу хяналт тавьж, зөрчил дутагдал үүсэхээс сэргийлэх, үүссэн даруйд холбогдох арга хэмжээг авч ажиллахыг комисс (С.Нарантуяа)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд холбогдох хууль, тогтоомж, тушаал, зааврыг баримтлан хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг), Мэргэжлийн хяналтын газар (Б.Батболд)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Захирамж-2021

20220124

Аймгийн Засаг даргын 2022 оны  
02 дугаар сарын 17 -ны өдрийн  
А/109 дугаар захирамжийн хавсралт



**МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРЛИЙГСУНГАХ БАЙГУУЛЛАГА**

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл сунгасан хугацаа	Тусгай зөвшөөрөл эхлэх хугацаа	Тусгай зөвшөөрөл дуусах хугацаа
1	Булган сумын "Сожид" хувийн хэвшлийн эмнэлэг	5 жилээр	2022.02.24	2027.02.24
2	Бугат сумын "Элгэн Бугат фарм" ХХК-ийн эмийн сан	5 жилээр	2022.01.24	2027.01.24
3	Баяннуур сумын "Баяннуур эм" ХХК-ийн эмийн сан	5 жилээр	2022.01.23	2027.01.23